

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№1



Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78.1-р заалт болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Даянбилгүүн-ийг томилсугай.

ЗӨВШӨӨРСӨН:


_____ Б.ЛХАГВАДОРЖ
_____ Д.ДАЯНБИЛГҮҮН
_____ Н.БАТГЭРЭЛ
_____ Д.АМГАЛАНБАЯР
_____ Б.ЭНХБАЯР
_____ ХИТОШИ ТАНИ
_____ ULUC BINGOL
_____ М.ТУЯА
_____ О.УРАНБАЙГАЛ


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:




/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№2

Улаанбаатар хот

Компанийн Гүйцэтгэх Захирал томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83-р заалт, “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн дүрмийн 3.35-р заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Бүрэнмэнд овогтой Лхагвадорж-ийг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№3

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82.1 заалт болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Даргаар Бат-Оргил овогтой Онон-г томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№4

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин урамшуулалын дэд хороог томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81.2 заалт болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын дэд хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Н.Батгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Хитоши Тани, хараат бус гишүүн Д.Амгаланбаяр нарыг томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№5

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хороог томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81.2 заалт болон “БиДиСЕК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Амгаланбаяр, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн О.Уранбайгал, хараат бус гишүүн М.Туяа нарыг томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№6


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хороог томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81.2 заалт болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Лхагвадорж, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Энхбаяр, хараат бус гишүүн Улуч Бингол нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№7

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76.1, 80.6 дахь заалтыг үндэслэн тус тус ТОГТООХ НЬ:

1. БиДиСЕК ҮЦК ХК-ийн Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга Д.Даянбилгүүнд компанийн аливаа байгуулж буй гэрээ, хэлэлцээр болон бусад холбогдох баримт бичигт БиДиСЕК ҮЦК ХК-г төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг олгосугай.
2. Энэхүү хурлын тогтоол нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болохыг тэмдэглэсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№8

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76.1, 80.6 дахь заалтыг үндэслэн тус тус ТОГТООХ НЬ:

1. БиДиСЕК ҮЦК ХК-ийн Санаа-Эгзэ ХХК-аас хөрөнгө оруулалтын зориулалтаар 8 сая ам.доллар хүртэлх зээлийг авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн Санаа-Эгзэ ХХК-аас авч буй хөрөнгө оруулалтын зориулалт бүхий ам.долларын зээлийн барьцаанд компанийн эзэмшлийн УБ, СБД, 8 хороо ЗӨЧ 27/1 хаягт байршилтай барилга болон газрыг барьцаалах зөвшөөрөл олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№9

Улаанбаатар хот

Татвар, санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах тухай

Компанийн тухай хуулийн 76.1, 80.6 дахь заалтыг үндэслэн тус тус ТОГТООХ НЬ:

1. БиДиСЕК ҮЦК ХК нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаас доорх дурдсан Татвар, санхүүгийн зөвлөх үйлчилгээг авахыг зөвшөөрсүгэй.
 - a. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг компанийн бүртгэлд буй Нэмж Төлөгдсөн Капитал дансанд бүртгэгдсэн хөрөнгөөр хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх хэлбэрээр нэмэгдүүлэх ажил гүйлгээтэй холбогдон үүсэх татварын нөлөөлөл;
 - b. Нэрлэсэн үнийг өсгөх хэлбэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон СТОУС болон НББОУС-ын дагуу Санхүүгийн тайлангийн бүртгэл, тооцоолол, бичилт хийхэд заавар,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03-ны өдөр

№10

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг <https://agm.mn/> хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах цогц системийг ашиглан 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 10 цагт цахимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. Компанийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, батлах;
 2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох;
 3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-р баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон цахимаар танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг Хавсралт №4-р баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах Үнэт цаасны компаниар нь дамжуулан 2023 оны 08 дугаар сарын 11-ний 17:00 цагаар тасалбар болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар харилцагчийн албаны Director Б.Онон , гишүүдээр VP С.Дөлгөөн, Associate А.Өлзиймаа нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Backoffice албаны мэргэжилтэн С.Халиун, гишүүн “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны мэргэжилтэн А.Ингүүнзаяа нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар
сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын
“Хавсралт №1

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 08-р сарын 14-ний өдөр 10:00 цагт <https://agm.mn/> хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах цогц системийг ашиглан цахимаар хуралдана.

Хаяг: <https://agm.mn/>

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:

2023 оны 07-р сарын 24-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, батлах;
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох;
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон цахимаар танилцах боломжтой.

Холбоо барих: 75551919-4, 99010179,88087239

Мэйл хаяг: Info@bdsec.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар
сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын
"Хавсралт №2

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ**

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:00-10:15
2	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын коммис)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	5 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах	40 минут
5	Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах	20 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын завсарлага	5 минут
8	Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах	15 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар
сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын
"Хавсралт №3

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох төслийн баримт бичиг
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл

